



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.09 № 1342
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Ч.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Чагнаадоржийн Бат-Эрдэнийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Чагнаадоржийн Бат-Эрдэнийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн


мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Чагнаадоржийн Бат-Эрдэнийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БАГАХАНГАЙ ДҮҮРГЭЭС БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ ЧАГНААДОРЖИЙН БАТ-ЭРДЭНИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол улсын эрх ашиг, олон нийтийн эрх, эрх чөлөөт байдлыг эрхэмлэн иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэх эрхэм зорилгоо болгон ажиллана.

Иргэн эрх чөлөөтэй амьдрах, сурч боловсрох, амьдралаа зохиож, хувийн өмчийг бий болгож, амьдралын тэгш боломжийг олгохыг зорино.

Агаарын бохирдлыг цогцоор нь шийдвэрлэх асуудлыг дэмжинэ.

Шинээр баригдаж буй хороолол, суурин газруудад сургууль, цэцэрлэгүүдийн хүртээмжийг сайжруулж, хүн амьдрах ээлтэй орчныг бүрдүүлэхэд идэвх гаргана.

Нутгийн өөрөө удирдах байгууллагад Байгалийн баялгийг хамгаалагч, ашиглагч, эзэмшигчид нь үйл ажиллагаагаа тайлагнадаг, цаашдын үйл ажиллагааг хамтран шийддэг тогтолцоонд шилжинэ.

Амьдарч буй орчныхоо төлөвлөлт, шийдвэрт иргэд өөрсдөө оролцдог Иргэний нийгмийг бүрдүүлнэ. Хувь хүний эрх, эрх чөлөөг зөрчин, амьдарч буй орчинд нь иргэний зөвшөөрөлгүйгээр төлөвлөлт хийх, барилга, зам барих, хүрээлэн буй орчныг нь сүйтгэдэг тогтолцоог Иргэдийн оролцоот төлөвлөлт, хэрэгжилтийг нэвтрүүлснээр өөрчилнө.

Байгаль орчноо хамгаалах, нутаг орноо хөгжүүлэхэд оршин суугаа иргэдийн дуу хоолой шийдвэрлэх хүчин зүйл байхаар эрх зүйн орчин, бодлогыг өөрчилнө.

Боловсролын салбар дахь хөрөнгө оруулалтыг дэмжинэ.


Эдийн засгийн үр ашиг муутай, байгаль орчинд хор хөнөөл ихтэй уурхайг ажиллуулахыг хориглоно.

Найдвартай, аюулгүй, мэдлэг, ур чадварт суурилсан үйлчилгээний салбартай улс орон болно.

Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг онцгойлон дэмжинэ.

Ахмадуудыг нийгмийн тустай ажил эрхлэх, хамтарч ажиллах санаачилгыг дэмжинэ.

Хүүхдэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгоно.



Орон нутгийн иргэний байгууллага, иргэдийн нөхөрлөлтэй байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог шинэ шатанд гаргана.

Амьсгалах агаартай, уух устай, аюулгүй амьдрах хоттой болох нөхцөлийг бүрдүүлнэ.

Хөтөлбөр боловсруулсан:



Ч.БАТ-ЭРДЭНЭ

2020.07.24

